

(А-ДБ-6) Суралцагч, сургалтын хэлбэрээр

ДБ-1: Дээд боловсролын статистик тайлан

ДЭД БҮЛЭГ-4.5: Дамжаа

Тайлангийн нэр 1: Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 20... / 20... оны хичээлийн жилийн мэдээ

Товч нэр: (А-ДБ-6) Суралцагч, сургалтын хэлбэрээр

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/31 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн мэдээллийг боловсролын түвшин, сургалтын хэлбэр бүрээр нийт суралцагч, дамжаа, хүйсээр ялган харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 11 сарын 01-ны дотор

Хамрах хүрээ: Дээд боловсролын сургалтын байгууллага(ДБСБ) нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем(ДБУМС)-ийн “Суралцагч” модульд суралцагчийн мэдээллийг оруулан тайлан бодуулж баталгаажуулсны дараа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага(БАЭТЗТБ) тайлан баталгаажуулан Үндэсний статистикийн хороонд ирүүлнэ.

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	3-ДБ-34	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр

Заавар: (А-ДБ-6) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

А. Үндсэн мэдээлэл Үзүүлэлт (багана А) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг сургалтын хэлбэр, төрөл, боловсролын түвшингээр нь мэдээллийг харуулна. МД (багана Б) -Мөрийн дэс дугаарыг дугаарлан бичнэ. Нийт суралцагчид (багана 1) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын нийт тоог бичнэ багана1=(2+3)=(4+7+10+13+16+19). Эрэгтэй (багана 2) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй нийт эрэгтэй суралцагчдын тоог бичнэ багана2=(5+8+11+14+17+20). Эмэгтэй (багана 3) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй нийт эмэгтэй суралцагчдын тоог бичнэ багана3=(6+9+12+15+18+21). Дамжаа (багана 4:21) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг суралцаж буй дамжаагаар ангилан гаргаж нийт тоог (багана 4, 7, 10, 13, 16, 19)-д, эрэгтэй суралцагчдын тоог (багана 5, 8, 11, 14, 17, 20)-д, эмэгтэй суралцагчдын тоог (багана 6, 9, 12, 15, 18, 21)-т тус тус бичнэ. Бүгд (мөр 1) -Тухайн хичээлийн жилийн эхэнд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдын нийлбэр тоог бичнэ мөр1=(2+3+4)=(5+9+13+17). Сургалтын хэлбэр (мөр 2:4) -Сургалтын өдөр, орой, эчнээ хэлбэрээр суралцагчдын тоог тохилох мөрөнд бичнэ. Боловсролын түвшин (мөр 5, 9, 13, 17) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг

боловсролын түвшингээр ангилан бичих бөгөөд сургалтын хэлбэрээр нь (мөр (6÷8), мөр(10÷12), мөр(14÷16), мөр(18÷20))-д тус тус суралцагчдын тоог бичнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120-оос, магистрын сургалт 150-аас, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Дипломын боловсрол (мөр 5:8) -Дипломын боловсролд суралцагчдын нийт тоог (мөр 5)-д, сургалтын хэлбэрээр нь (мөр 6÷8)-д бичнэ мөр5=(6÷8). Бакалаврын боловсрол (мөр 9:12)-Бакалаврын боловсролд суралцагчдын нийт тоог (мөр 9)-д, сургалтын хэлбэрээр нь (мөр 10÷12)-д бичнэ мөр9=(10÷12). Магистрын боловсрол (мөр 13:16) -Магистрын боловсролд суралцагчдын нийт тоог (мөр 13)-т, сургалтын хэлбэрээр нь (мөр 14÷16)-д бичнэ мөр13=(14÷16). Докторын боловсрол (мөр 17:20) -Докторын боловсролд суралцагчдын нийт тоог (мөр 17)-д, сургалтын хэлбэрээр нь (мөр 18÷20)-д бичнэ мөр17=(18÷20). Орц: “Суралцагч” модуль Суралцагчийн элсэлт, шилжилт хөдөлгөөн, үндсэн мэдээлэл, сургалтын мэдээлэл, статистик мэдээллийг оруулсны дараа системээр тодорхой дүрмээр бодолт хийж гарна. Модуль: Суралцагч Асуулгын маягт:ДБСБ-ын суралцагчийн асуулгын маягт- АМ-4